

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 28

Улаанбаатар хот

Дугаар	ХБТББ-т тусгагдсан зорилт үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ(сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтод түвшин, үр дүн (Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (Сая.төг)	Төсвий Гүйцэтгэл (Сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО												
4.1.8	НЗДҮАХ-5.1.2	Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.	-	УБЗАА, Дүүргүүд, ХСХГ	Дүүргийн төсөв	-	488	506	-	-	-Хотын стандарт, хяналтын газрын даргын баталсан 2023 оны 02-13-04/023/03 дугаартай “Стандартын шаардлага хангахгүй эрсдэлтэй хүүхдийн тоглоомын талбайд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу нийт 474 хүүхдийн тоглоомын талбайг батлагдсан хотын стандартын хяналтын хуудсаар шалгаж, улсын байцаагчийн 88 зөвлөмжийг 474 байршилд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн. Мөн судалгаанд хамрагдсан 974 хүүхдийн тоглоомын талбайн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийг тодруулах зорилгоор НХОГ, НӨХГ, төвийн 6 дүүргийн Засаг дарга нарт 2023 оны 01/460-469 тоот албан	100%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											<p>бичиг хүргүүлж, ирүүлсэн судалгааг нэгтгэв.</p> <p>-Нийслэлийн хэмжээнд 79 байршилд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулсан. Дээрх ажлын хүрээнд UCS1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандартыг хангуулахаар захиалагч болон гүйцэтгэгч компанид холбогдох зөвлөмж, чиглэлийг тогтмол хүргүүлж ажилласан.</p>	
4.2.5	НЗДҮАХ-5.2.1	<p>Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Агаарын чанарын стандарт”-ыг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлнэ.</p>	-	ХСХГ	Нийслэлийн төсөв	50.0	-	1	-	-	<p>“Агаарын чанарын стандарт”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Агаар, орчны бохирдолтой тэмцэх газартай 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр уулзалт зохион байгуулан хотын стандарт боловсруулах ажлын даалгаварт санал авч, судалгааны материал солилцсон. Хотын стандартын төслийг боловсруулан дээрх газраас 2023 оны 01/628 тоот албан бичгээр санал авсан.</p> <p>Хотын стандарт боловсруулах ажлын явц, мэдээллийг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Агаарын чанартай холбоотой судалгааг дахин нарийвчлан хийх ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэсэн.</p>	90%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
4.3.21	НЗДҮАХ-5.3.6	“Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага”, “Хөв цөөрөм үүсгэх болон хур тунадасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага” баримт бичгийг батлуулж, хэрэгжилтийг хангуулна.	-	ХСХГ, УБЗАА	Нийслэлийн төсөв	-	-	2	-	-	Хотын стандартын төслийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдаанд танилцуулсан. Төслийг хянан тохиолдуулах ажлын хэсэг байгуулан 2024 оны 02 дугаар сарын 15-ны дотор Зөвлөлийн хуралдаанд эргэн танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн. Дээрх хотын стандартын төсөлд иргэд, олон нийтээс санал авахаар байгууллагын standard.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	70%
4.3.22	НЗДҮАХ-5.3.6	Орон сууцны хороолол дахь ногоон байгууламжийн техникийн ерөнхий шаардлага баримт бичгийг батлуулж, хэрэгжилтийг хангуулна.	-	ХСХГ	Нийслэлийн төсөв	-	-	1	-	-	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 20 дугаар тогтоолоор “Ногоон байгууламж” бүлгийн 5 хотын стандарт батлагдсан бөгөөд “Орон сууцны хороолол дахь ногоон байгууламжийн ерөнхий шаардлага”-аар гарын авлага боловсруулж байна.	70%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
4.3.23	НЗДҮАХ-5.3.6	Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага баримт бичгийг батлуулж, хэрэгжилтийг хангуулна.	-	ХСХГ	Нийслэлийн төсөв	-	-	1	-	-	Хотын стандартын төслийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдаанд танилцуулсан. Төслийг хянан тохиолдуулах ажлын хэсэг байгуулан 2024 оны 02 дугаар сарын 15-ны дотор Зөвлөлийн хуралдаанд эргэн танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн. Дээрх хотын стандартын төсөлд иргэд, олон нийтээс санал авахаар байгууллагын standard.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	90%
4.3.24	НЗДҮАХ-5.3.6	Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын хөрсөнд дахин сэргээлт хийх ерөнхий шаардлага, удирдамж арга зүйн баримт бичгийн төсөл боловсруулж, мөрдүүлнэ.	-	ХСХГ	Нийслэлийн төсөв	250.0	-	1	-	-	Газрын даргын 2023 оны А/32 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж тус гарын авлагыг хянан тохиолдуулж, шинэчлэгдсэн эрх зүйн баримт бичгийг тусган засвар сайжруулалт хийсэн. Цаашид Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад гарын авлагыг цахим хэлбэрээр түгээх арга хэмжээг зохион байгуулна.	70%
5.1.22	НЗДҮАХ-6.1.4	Хотын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулж батлуулан мөрдүүлж эхлүүлнэ.	-	ХСХГ	-	-	-	100	-	-	Хотын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үндсэн цогц харилцааг зохицуулсан журмын төсөл боловсруулж, иргэд олон нийтээс 712 дэмжсэн санал, нийслэлийн нутгийн захиргааны 34 байгууллагаас ирүүлсэн 41 тухайлсан саналыг тусгаж 2023 оны 15, 20 дугаар хуралдаанд	90%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											танилцуулж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.	
5.1.24	НЗДҮАХ-6.1.7	Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд орон сууцны барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ.	-	ХБХГ, ХСХГ	Төр, хувийн хэвшлийн түншлэл	-	-	19864	-	-	-Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийн дагуу 2023 онд 33 аж ахуйн нэгж, байгууллагын 3480 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулсан. -Нийслэлийн хэмжээнд гэр хорооллын дахин төлөвлөлтөөр нийт 23 байршилд 53 төсөл хэрэгжүүлж байгаагаас 39 нь үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, 14 нь тодорхой шалтгааны улмаас цуцлагдсан бөгөөд гэр хорооллын газрыг дахин барилгажуулах үнэлгээний хорооны гишүүнээр Барилгын техникийн хяналтын (хот төлөвлөлт) улсын байцаагч ажиллаж, 3 байгууллагын төсөл хэрэгжүүлэгчийг цуцлуулах санал зөвлөмжийг хүргүүлсэн. -Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 247 өргөдөл гомдлын хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулж, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн. -Гэр хорооллын дахин төлөвлөлтийг батлагдсан зураг төслийн дагуу зохион байгуулах талаар Газрын даргын албан мэдэгдлийг Хот	100%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											байгуулалт, хөгжлийн газарт хүргүүлж, гэр хорооллын дахин төлөвлөлтөд гарч буй зөрчлүүд, тулгамдаж буй асуудлын талаар Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзоригт 2023 оны 01/1478 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн.	
6.1.27	НЗДҮАХ-6.1.5	Нийслэлийн авто зам, тээврийн салбарт мөрдүүлэх хотын стандартыг боловсруулж батлуулна.	-	ХСХГ	Нийслэлийн төсөв	300.0	-	3	-	-	Нийслэл хотын авто зам, замын байгууламжийн төлөвлөлт, тэмдэг тэмдэглэгээ, материал хийц болон засвар арчлалтын чанарыг сайжруулах, цаашдын чиг хандлагыг оновчтой тодорхойлох зорилгоор авто зам, замын байгууламжийн салбарт мөрдүүлэх дараах 2 хотын стандартын төслийг боловсруулав. Үүнд: 1. "Хотын авто зам төсөллөх ерөнхий шаардлага", 2. "Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтад тавигдах ерөнхий шаардлага". Мөн нийтийн тээврээр зорчигчдын тав тухтай байдлыг хангах зорилгоор "Нийтийн тээврийн зогсоолын зорчигчийн хүлээлгийн танхимд тавигдах ерөнхий шаардлага" хотын стандартын төслийг боловсруулж, дээрх 2 төслийн хамт Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдаанд танилцуулсан. Эдгээрийг хянан тохиолдуулах	70%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											ажлын хэсэг байгуулж 2024 оны 02 дугаар сарын 15-ны дотор Зөвлөлийн хуралдаанд эргэн танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барих асуудлыг шийдвэрлэнэ.	
Дундаж биелэлт:												83.3%

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.ТӨМӨРДУЛАМ

Э.ДАВААХАТАН

Г.ЭНХЭЭ

М.ГАЧМАА